



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

**2018 ОНЫ 06 ДУГААР САРЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ
2018 ОН**

АГУУЛГА

НЭГ. ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР.

1.1. Удирдлага, зохион байгуулалтын талаар	3
1.2. Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны талаар	3
1.3. Өргөдөл, гомдол түүний шийдвэрлэлтийн талаар	4
1.4. Сургалт, мэдээллийн талаар	4
1.5. Санхүү, хөрөнгө оруулалтын талаар	5
1.6. Хяналт-шинжилгээ, үнэлгээний талаар.....	6
1.7. Хяналт шалгалтын талаар	6

ХОЁР. САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИНГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР.

2.1. Хууль, тогтоомжийн талаар	8
2.2. Сайдын шийдвэрийн талаар	8
2.3. Стандарт, нормативийн талаар	9
2.4. Хууль, Шүүхийн байгууллагад төлөөлөн оролцсон ажлын талаар	10

ГУРАВ. УЛСЫН ИХ ХУРАЛ, ЗАСГИЙН ГАЗАРТ ТАВЬЖ ШИЙДВЭРЛҮҮЛСЭН БОЛОН ШИЙДВЭРЛҮҮЛЭХАСУУДАЛ:..... 11

ДӨРӨВ. САЛБАРЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР:

4.1. Авто замын талаар	12
4.2. Авто тээврийн талаар	13
4.3. Төмөр замын талаар	14
4.4. Агаарын тээврийн талаар	15

ТАВ. ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР.....15

ЗУРГАА. БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР.....16

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ 2018 ОНЫ 06 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ТОВЧ ТАЙЛАН

2018 оны 07 дугаар сарын 04

Улаанбаатар хот

Зам, тээврийн хөгжлийн яам нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, яамны үйл ажиллагааны стратегийн зорилтын хүрээний бодлого, зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд яамны 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

НЭГ. ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР.

1.1. Удирдлага, зохион байгуулалтын талаар:

Зам, тээврийн сайдын 2013 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 227 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн яамны шуурхай зөвлөгөөнийг зохион байгуулах, өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтэд хяналт тавих журам”-д заасны дагуу сайдын шуурхай зөвлөгөөнийг 2018.06.04, 2018.06.25-ны өдрүүдэд 2 удаа зохион байгуулж яамны нэгж, харьяа байгууллага, агентлагт нийт 32 үүрэг, даалгавар өгөгдсөнөөс хэрэгжилт 70%-тай, Төрийн нарийн бичгийн даргын шуурхай зөвлөгөөнийг 2018.06.08-ны өдөр зохион байгуулж 8 үүрэг, даалгавар өгөгдсөнөөс хэрэгжилт 85%-тай байна.

1.2. Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны талаар:

Зам, тээврийн хөгжлийн яамны албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг холбогдох хууль, дүрэм, журам, стандартын дагуу хөтлөн явуулж, яаманд ирсэн хариутай бичигт бүртгэл хяналтын карт хөтөлж, шийдвэрлэлтийн байдалд хяналт тавьж, хариу өгөх хугацаа хэтэрсэн бичгийн мэдээг 7 хоног тутам гарган удирдлагуудад танилцуулж, холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.

Тус яаманд 2018 оны 06 дугаар сард нийт 1017 бичиг ирснээс хариутай 430 бичиг, хариугүй 587 бичиг, шийдвэрлэсэн 211 бичгийг сканердаж бүртгэл мэдээллийн санд орууллаа.

Ирсэн бичгийг удирдлагын цохолтоор Бодлого, төлөвлөлтийн газарт-171, Төрийн захиргааны удирдлагын газарт-283, Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт-155, Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт-87, Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт-141, Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтэс-97, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт-83 шилжүүлсэн байна.

Ирсэн бичгийг байгууллагаар нь ангилж үзвэл: Монгол Улсын Засгийн газраас-18, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас-35, УИХ-ын гишүүн, байнгын хороодоос-21, яамдуудаас-189, Элчин сайдын яамдаас-2, Авилгатай тэмцэх газраас-5, Төрийн албаны зөвлөлөөс -4, аймаг, орон нутаг-48, дүүрэг, хорооноос-17, шүүх, цагдаагийн байгууллагаас-32, төсөл хэрэгжүүлэх нэгжүүдээс-49, харьяа байгууллагаас-156, компаниас-210, холбоодоос-25, бусад аж ахуйн нэгж, байгууллагаас-143 бичиг ирсэн байна.

Агуулгаар нь ангилбал: Санал авах-72, хүсэлт гаргах, хүргүүлэх, уламжлах-258, гүйцэтгэл, санхүүжилт хүссэн-23, тусгай зөвшөөрөл-32, шагнал-25, хариу ирүүлсэн-146, биелэлт, тайлан, мэдээ ирүүлсэн-83, мэдээлэл авах-3, асуудал шийдвэрлүүлж дэмжлэг хүссэн-16, бусад 206 бичиг тус тус байна.

Яамнаас гадагш-548 албан бичиг явуулж 17908 хуудас сканердаж able програмд оруулсан.

Явуулсан бичгийг газар тус бүрээр ангилбал: Бодлого төлөвлөлтийн газар -24, Төрийн захиргааны удирдлагын газар-86, Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар- 105, Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар-53, Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар-70, Хяналт - шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар-42, Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтэс-38, бусад-130 албан бичиг явуулсан.

1.3. Өргөдөл, гомдол түүний шийдвэрлэлтийн талаар:

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн дагуу ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг цаг тухайд нь цахим болон дэвтрээр бүртгэн карталж удирдлагад танилцуулан холбогдох газар, хэлтэс, мэргэжилтэнд хувиарлан шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллаж байна.

2018 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс 2018 оны 06 дугаар сарын 29-ний байдлаар яамны хэмжээнд иргэд, албан хаагчдаас нийт 27 өргөдөл, гомдол ирсэнийг удирдлагад танилцуулан цохолт хийлгүүлж холбогдох албан тушаалтанд хуваарилан ажиллалаа. Шийдвэрлэж хариу өгсөн 15, хяналтад байгаа 12 өргөдөл, гомдол, шийдвэрлэлтийн хувь 55,56 хувьтай байна.

Дээрх өргөдөл, гомдол нь ээлжийн амралт олгуулах, цалинтай, цалингүй чөлөө хүссэн зэрэг агуулгатай байна.

Иргэд болон албан хаагчдын санал, хүсэлтийг хүлээн авах “Санал хүсэлт”-ийн хайрцгийг 1 давхарт байрлуулан санал хүсэлтийг бүртгэх, хүлээн авах албан тушаалтныг томилон тогтмол ажиллуулж байна.

1.4. Сургалт, мэдээллийн талаар:

Төрийн нарийн бичгийн даргын баталсан 2018 оны сургалтын төлөвлөгөөний дагуу байгууллагын албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх, ажлын бүтээмжийг сайжруулах, давтан сургах, мэргэшүүлэх зорилгоор давхардсан тоогоор 95 албан хаагчийг сургалтад хамруулсан байна. Тухайлбал:

1. Авилгатай тэмцэх газраас зохион байгуулж буй дараах сургалтад яамны болон яамны харьяа байгууллагын албан тушаалтнуудыг хамруулсан. Үүнд:
 - Санхүү, төсөв хариуцсан ажилтнуудад зориулсан сургалтад 23 албан хаагч,
 - Дотоод хяналт, аудитын нэгжийн дарга нарт зориулсан сургалтад 12 албан тушаалтан
 - Төрийн үйлчилгээний албан тушаалтнуудад зориулсан сургалтад 60 албан тушаалтан

2. Удирдлагын академийн Төрийн албан хаагчийн мэргэшүүлэх сургалт, төрийн удирдлагаар мэргэшүүлэх “Гараг”-ийн сургалтад төрийн зардлаар 1 албан хаагч,

3. Засгийн газрын 1996 оны 265 дугаар тогтоолын дагуу яамны албан хаагч нарт зориулсан мэдээлэл, сурталчилгааны Мэдээллийн цаг арга хэмжээг 2018 оны 06 дугаар сарын 08, 22-ны өдрүүдэд "Инновацийн талаар төрөөс баримтлах бодлого", "Эрүүл мэндийн сэтгэл зүй" сэдвээр тус тус мэдээлэл хийсэн.

Автотээврийн салбарын мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх, салбарын ажиллагсдын мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотын "Өвөр Монгол" их сургууль хооронд хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд "Олон улсын тээврийг хөнгөвчлөх" богино хугацааны сургалтад Зам, тээврийн хөгжлийн яам, "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ, Механик, тээврийн сургууль, Үндэсний батлан хамгаалахын их сургууль, Хөдөө аж ахуйн их сургууль, Монголын автотээвэрчдийн нэгдсэн холбооны төлөөллөөс бүрдсэн нийт 21 хүн 2018 оны 06 дугаар сарын 19-нөөс 25-ны хооронд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотын "Өвөр Монгол" их сургуульд богино хугацааны сургалтад хамрагдав.

1.5. Санхүү, хөрөнгө оруулалтын талаар:

Сайдын багцын харьяа төсөвт байгууллагуудын төлбөр тооцоог Сангийн сайдын батлагдсан төсвийн зарцуулалтын эрхийн баталгааг үндэслэн 06 дугаар сард нийт 212 ширхэг 3,9 тэрбум төгрөгийн зарлагын гүйлгээг анхан шатны баримттай тулган шалгаж төсвийн тухай хууль болон холбогдох журам, дүрмийн дагуу төлбөр тооцоог хурдан шуурхай, үнэн зөв хийж гүйцэтгэн хянан баталгаажуулсан.

Хөрөнгө оруулалтын таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний мэдээ, цалингийн зардлаас бусад таван саяас дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээ Засгийн газрын шилэн дансны цахим хуудсанд байршуулсан.

Норм, нормативын санд 2018 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар авто зам, замын байгууламжийн барилгын ажлын санхүүжилт болон норм, стандарт, техникийн баримт бичиг борлуулснаас нийт 213,586,962 төгрөгийн орлого орж, зөвлөх үйлчилгээний 2 ажлын 50,216,170 төгрөгийн зарлага гарсан.

Албан хаагчдын ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ажлын байрны бичиг хэргийн материалыг сар бүр захиалгын хуудсын дагуу захиалан тарааж байна. 2018 оны 06 дугаар сарын 30-ны байдлаар бичиг хэргийн зардал 16,178,300. төгрөг, бага үнэтэй, түргэн элэгдэх бараа материалын зардалд 5,996,838 төгрөг, шуудан, холбоо, интернетийн төлбөрт 6,936,161 төгрөгийн зардлууд зарцуулагдаад байна. Мөн бусад техник хэрэгслээр цаг тухай бүр ханган ажиллаж байна.

Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих 9 төсөл, арга хэмжээний 8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Сангийн яамнаас эрх нээсний дагуу гүйцэтгэгчийн дансанд олгосон. Захиалагч гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээний дагуу 17 төсөл, арга хэмжээний 6,4 тэрбум төгрөгийн баталгаат хугацааны барьцаа хөрөнгийг Сангийн яамнаас эрх нээсний дагуу чөлөөлж, гүйцэтгэгчийн дансанд олгосон.

Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст сар бүр тогтсон хугацаанд нийгмийн даатгалын тайланг гарган тушааж байна. Албан хаагчдын жирэмсний тэтгэмж, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийн тооцоог гаргаж, нийгмийн даатгалын хэлтсээс нэхэмжлэн, дансанд орсон тухай бүр албан хаагчдад тооцож олгож байгаа болно. 2018 оны 06 дугаар сарын 30-ний байдлаар нийт 13,529,779 төгрөгийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг тооцсоны дагуу 26 албан хаагчид олгосон.

1.6. Хяналт-шинжилгээ, үнэлгээний талаар:

УИХ-ын 2017 оны 42 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд Зам, тээврийн салбарт хэрэгжүүлэхээр туссан арга хэмжээний хэрэгжилтийн явцыг эхний хагас жилээр нэгтгэн гаргаж, Засгийн газрын 2018 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д нийцүүлэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж байна.

Улсын Их Хурлын 7 тогтоолын 13 заалт, Улсын Их Хурлын Байнгын хорооны 5 тогтоолын 8 заалт, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 3 зөвлөмжийн 4 заалт, Засгийн газрын 96 тогтоолын 131 заалт, Ерөнхий сайдын 3 захирамжийн 3 заалт, Засгийн газрын хуралдааны 86 тэмдэглэлийн 129 заалт буюу нийт 201 шийдвэрийн 310 заалтыг хяналтад авч биелэлтийг холбогдох газруудаас авч нэгтгэн, явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж байна.

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж байна.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 160 тушаалын 295 заалтыг, Төрийн нарийн бичгийн даргын 77 тушаалын 130 заалтыг тус тус хяналтад авч, хэрэгжилтийн байдалд 2018 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдэж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчаас Төсвийн шууд захирагчтай байгуулсан Үр дүнгийн гэрээний биелэлт, яамны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, яамны дотоод бүтцийн нэгжүүдийн дарга/менежер/ нарын үр дүнгийн гэрээ, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, явцын үнэлгээ хийж байна.

Хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар хийгдсэн 86 төслийн хэрэгжилтэд хийсэн хяналт, шалгалтын тайлан хяналтын шатанд танилцуулагдаж байна.

1.7. Хяналт шалгалтын талаар:

Төрийн нарийн бичгийн даргын баталсан 2018.0.6.07-ны өдрийн 38-07-0901/24 удирдамжийн дагуу “Өвөрхангай-А33А” ТӨХК-ийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаа, Улсын чанартай А0301 дугаартай Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн 146 км, А0302 дугаартай Арвайхээр-Баянхонгор чиглэлийн 138 км хатуу хучилттай авто замын засвар арчлалт, ашиглалтын бэлэн байдалд хяналт шалгалтыг 2018.06.11-17-ны өдрүүдэд хийж гүйцэтгэсэн.

А0301 дугаартай Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн 146 км авто замд 2018 оны 06 дугаар сарын 18-ны өдөр Улсын байцаагчийн 038-07-067/21 дугаартай, А0302 дугаартай Арвайхээр-Баянхонгор чиглэлийн 138 км хатуу хучилттай авто замуудад 2018 оны 06 дугаар сарын 18-ны өдөр Улсын байцаагчийн 038-07-067/22 дугаартай албан шаардлагыг тус тус хүргүүлээд байна.

Төрийн нарийн бичгийн даргын баталсан 2018 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 38-07-0901/23 удирдамжийн дагуу “Багануур-А33А”, “Харгүй”, “Талын зам” ТӨХК-иуд болон “Дорнод авто зам” ХК-ийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаа, авто замын засвар арчлалт, ашиглалтын бэлэн байдалд хяналт шалгалтыг 2018 оны 06 дугаар сарын 18-28-ны өдрүүдэд хийж гүйцэтгэв.

Зам, тээврийн хөгжлийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газартай байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу 2018 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дэд даргын баталсан 02/150 дугаартай удирдамжийн дагуу Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн Яармагийн хуучин гүүрийг засварлах, шинэ гүүр барих төслийн барилгын ажилд төлөвлөгөөт хяналт шалгалт хийж шалгалтын тайлан, дүгнэлтийг боловсруулж илэрсэн зөрчил дутагдал дээр Улсын ахлах байцаагчийн 07/096/124 дугаартай албан шаардлагыг гүйцэтгэгч “СТСЕ” ХХК-д хүргүүлсэн.

Зам, тээврийн хөгжлийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газартай байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу 2018 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дэд даргын баталсан 02/150 дугаартай удирдамжийн дагуу Улаанбаатар хотын Яармагийн хуучин гүүрийг засварлах, шинэ гүүр барих төслийн барилгын ажилд төлөвлөгөөт хяналт шалгалт хийж илэрсэн зөрчил дутагдал дээр Улсын /ахлах/ байцаагчийн 2018 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 07/096/125, 38-07-077/18 дугаартай албан шаардлагыг гүйцэтгэгч “Чайна Райлвэй Твэнти Бюро Групп Монголиа” ХХК-д хүргүүлсэн.

“ДТХ партнерс” ХХК, “ТЕХСИГ” ХХК-иудын үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар гарсан дүгнэлтийн дагуу 38/07/020/05 38/07/020/04 дугаар зөвлөмж гаргаж хүргүүлэв.

ХОЁР. САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИНГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР:

2.1. Хууль тогтоомжийн талаар:

Тайлангийн хугацаанд нийт 17 гэрээг хянаж, хууль эрх зүйн үндэслэлийг хянасан байна. Тухайлбал:

1. Улсын чанартай авто замын өвлийн арчлалтын онцгой ажлын захиалагч, гүйцэтгэгч нарын хооронд байгуулсан гэрээ
2. Олон улс, улсын чанартай авто замуудад хөдөлгөөний эрчмийн тооллого, судалгаа хийх ажлын захиалагч, зөвлөхийн хооронд байгуулах гэрээ
3. Олон улс, улсын чанартай авто замуудад хөдөлгөөний эрчмийн тооллого, судалгаа хийх ажлын захиалагч, зөвлөхийн хооронд байгуулах гэрээ

2.2. Сайдын шийдвэрийн талаар:

“Авто замын норм, норматив сангийн ажиллах журам”-ыг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 142 дугаар тушаалаар батлав.

Архангай, Баянхонгор, Дорнод, Өвөрхангай, Сүхбаатар, Төв, Хэнтий аймгуудын Засаг дарга нараас ирүүлсэн саналын дагуу хот хоорондын нийтийн тээвэрлэлтийн шинэ чиглэлийг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 134 дүгээр тушаалаар батлав.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 128 дугаар тушаалаар Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд “Автотээврийн хэрэгслээс ялгарах утааг багасгах талаар санал, холбогдох шийдвэрийн төсөл, төлөвлөгөө боловсруулах” үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулав.

“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын харьяа Баян-Өлгий аймгийн автотээврийн төвийн “Автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажил эрхлэх” тусгай зөвшөөрлийг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 143 дугаар тушаалаар сэргээв.

2.3. Стандарт, нормативын талаар:

Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2018 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаар доорх стандартуудыг батлуулаад байна:

- Замын тэмдэглэгээний материал. Физик шинж чанар. MNS EN 1871 : 2018
- Зам барилгын материал. Нефтийн өтгөн битум. MNS GOST 33133 : 2018
- Асфальтбетон болон органик эрдэс (органо-минераль) хольцод хэрэглэх эрдэс нунтаг. Техникийн шаардлага. MNS GOST 52129 : 2018
- Уулархаг нутгийн авто зам дагуу зэрлэг амьтдад зориулсан гарц. Ерөнхий шаардлага
- Аккумуляторын батарейгаар ажилладаг цахилгаан автомашин. Хийц, аюулгүй байдалд тавих техникийн шаардлага **MNS **** : 2018**
- Автотээврийн хэрэгсэл. байгалийн хийгээр цэнэглэх компрессорын станцын аюулгүй ажиллагаанд тавих шаардлага **MNS **** : 2018**
- Автотээврийн хэрэгсэл. Байгалийн хийгээр ажилладаг автотээврийн хэрэгсэл. Ерөнхий шаардлага **MNS **** : 2018**
- Автотээврийн хэрэгслийг байгалийн хийгээр цэнэглэх компрессорын станцын техник ашиглалтанд тавих шаардлага **MNS **** : 2018**
- Зам төмрийн толгойн түвшинд авто угсрааны өндөр шалгах загвар. Баталгаажуулалтын арга хэрэгсэл ” **MNS **** : 2018**

Мөн Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2018 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаар “Автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын тэмдэг. 2-р хэсэг: Ерөнхий шаардлага” MNS4410-2 : 2017 стандартад нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 146 дугаар тушаалаар Зам, тээврийн стандартын үзлэгийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан зохион байгуулах салбар комиссыг байгуулав.

2.4. Хууль, Шүүхийн байгууллагад төлөөлөн оролцсон ажлын талаар:

Тайлангийн хугацаанд шүүхээр хэлцэгдэж байгаа 11 хэрэг маргааныг ангилвал Засгийн газрыг төлөөлж оролцож байгаа 3 хэрэг, Зам, тээврийн хөгжлийн ямаа төлөөлсөн 8 хэрэг байна. Харин хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусгавар болсон **13** хэрэг байна. Үүнд:

1. Иргэний **2** хэрэг
2. Захиргааны **11** хэргийг тус тус шийдвэрлэсэн байна.

Зам, тээврийн хөгжлийн сайдад холбогдох “Хотгор зам” ХХК-ийн нэхэмжлэлтэй иргэний Давж заалдах шатны шүүхийн 2018 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн шүүх хуралд хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож, нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгов. Засгийн газрыг төлөөлж, нэхэмжлэгч “Жуулчин монгол наадам” ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 06 дугаар

сарын 25-ны өдрийн хурал дээр хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хувьд гомдол гаргаж, шүүх хуралдааныг хойшлуулав.

ГУРАВ. УЛСЫН ИХ ХУРАЛ, ЗАСГИЙН ГАЗАРТ ТАВЬЖ ШИЙДВЭРЛҮҮЛСЭН БОЛОН ШИЙДВЭРЛҮҮЛЭХ АСУУДАЛ:

“Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”-д өөрчлөлт оруулах тухай тогтоолын төслийг УИХ-ын 2018 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн чуулганаар хэлэлцэн баталсан.

“Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийн Монголын талын хувь эзэмших төрийн өмчит компанийн дүрмийг 2018 оны 06 дугаар сарын 28-ны өдөр баталж, гүйцэтгэх захиралыг томилов.

Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-д Зүүнбаян-Ханги, Эрдэнэт-Овоот-Арцсуурь чиглэлийн төмөр замуудыг нэмэлтээр оруулах Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж 2018 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар батлуулав.

Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийн өөрийн хэрэгцээнд импортоор оруулах дизель түлшийг онцгой албан татвараас чөлөөлөх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, мөн тус нийгэмлэгийн дотоод хэрэгцээнд 1998-2015 онд импортолсон дизелийн түлшний онцгой албан татварт төлсөн 73.8 тэрбум төгрөгийг “Японы Олон улсын хамтын ажиллагааны банк”-аас авсан МОНП-1, МОНП-2 хөнгөлөлттэй зээлийн гэрээний дагуу тооцсон алданги, зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрөөс суутган тооцох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг 2018 оны 06 дугаар сарын 29-ний өдөр Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцэхээр байсан боловч Улсын Их Хурлын чуулган хэлэлцэлж амжилгүй хаасан. Иймд намрын чуулганаар хэлэлцүүлэхээр болсон.

Монгол Улс, ОХУ-ын Засгийн газар хоорондын Төмөр замаар дамжин өнгөрөх ачаа тээвэрлэх нөхцөлийн тухай хэлэлцээрийг 2018 оны 06 дугаар сарын 08-ны өдөр Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ болон ОХУ-ын Тээврийн сайд Е.И.Дитрих нар байгуулав.

Олон улсын далайн байгууллагаас хийсэн Аудитын шалгалтын зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор тус салбарт нэгдэн орсон Монгол Улсын далайн салбарын олон улсын гэрээ, конвенцийг хэрэгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний төсөл, Засгийн газрын тогтоол болон тэмдэглэлийн төсөл, танилцуулга, холбогдох материалыг боловсруулан Засгийн газрын 2018 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан.

“Түр хугацаагаар оруулах тухай конвенц”-ийн тухай танилцуулга, Засгийн газрын шийдвэрийг боловсруулж, Засгийн газрын гишүүдээс саналыг авч тусган, шийдвэр гаргуулахаар Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 01/3094 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэв.

“Агаарын тээврийг хялбаршуулах үндэсний хөтөлбөр”-т нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 01/3012 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэв.

“Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр”-т нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 01/3013 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэв.

ДӨРӨВ. САЛБАРЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР:

4.1.Авто замын талаар:

БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжих Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн Загастайн давааны 67 км хатуу хучилттай авто замын төсөлд зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр хятадын талын санал болгосон компанитай хэлэлцээ хийж, гэрээ байгуулах болон барилгын ажлын гүйцэтгэгч компанитай байгуулсан арилжааны гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлыг зохион байгуулах Ажлын хэсгийг Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн тушаалаар байгуулж холбогдох гэрээнүүдийг байгуулж Сангийн яаманд хүргүүлэв.

Булган аймгийн Дашинчилэн сумын зам хариуцагч, Архангай аймгийн Тариат сумын зам хариуцагч, Завхан аймгийн төв Улиастай хотын зам хариуцагч, Ховд аймгийн Дарви сумын зам хариуцагч, Ховд аймгийн Булган сумын зам хариуцагч нарын олон улс, улсын чанартай авто зам, замын байгууламжийн урсгал засвар, арчлалтын ажлыг хариуцан ажиллах зам хариуцагчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог 2018 оны 06 дугаар сарын 28-ны өдөр Төрийн нарийн бичгийн даргын 200 дугаартай тушаалаар баталсан.

“Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд хэрэгжиж буй зам барилгын ажлыг 2018 оны 06 дугаар сарын 08-ны өдрөөс 17-ны хооронд хэрэгжилтийн явцтай газар дээр нь танилцаж, холбогдох дүгнэлт, саналыг өгч ажиллав.

“Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төсөл”-ийн замаас Ховд аймгийн Мөст сум чиглэлийн 20 км авто замын барилгын ажлын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулах тендерийг 2018 оны 06 дугаар сарын 18-ны өдөр нээсэн бөгөөд үнэлгээний ажлыг хэрэгжүүлж байна.

Дараах ажлуудын гэрээг байгуулан ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгож барилгын ажлыг эхлүүлэд байна. Үүнд:

- Гурванбулаг-Хишиг-Өндөр чиглэлийн 22 км хатуу хучилттай авто замын барилгын ажил
- “Туул зөрлөг орчмын төмөр замын доорх автомашины нүхэн гарц /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 11 дүгээр хороо/” ажил
- Баян-Өлгийн аймгийн Улаанхус сумын Согоогийн голын төмөр бетон гүүрийн барилгын ажил
- Төв аймгийн сумын төвийн 1км, Дорнод аймгийн Баянтүмэн сумын 1,7км, Туул гол орчмын төмөр замын доорх автомашины нүхэн гарц зэрэг төслүүд

- Галын голын 36.7 у/м төмөрбетон гүүр, Ширээгийн голын 90.9 у/м төмөрбетон гүүрийн барилгын ажил
- “Хорооллын доторх авто замын засвар, 3 км /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 16 дугаар хороо/” гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах зөвлөмжийг Захиалагчид хүргүүлсэн.
- Сумын төвийг Мянганы замтай холбох хатуу хучилттай авто зам /Дорнод Баянтүмэн/
- 23-р байрны хойд талын автомашины зогсоол /УБ, СБ дүүрэг, 5-р хороо/

Онон голын төмөр бетон гүүрийн засвар, 238.9 у/м /Хэнтий, Дадал, Баян-Адарга сум/ гүүрийн барилгын ажил, Туул голын Сонгинын төмөр бетон гүүр /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 12 дугаар хороо/-ийн түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй төслийн зураг төсөл боловсруулах, гүүрийн барилгын ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг дахин зарласан.

Авто замын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх нийт 16 журмын төслийг боловсруулах ажлын хэсгүүдийг Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 191 дүгээр тушаалаар шинэчлэн байгуулсан.

Дээрх ажлын хэсэг тайлант хугацаанд “Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах журам”, “Авто замын салбарын мэргэжилтэй ажилтан бэлтгэх, давтан сургах, мэргэжлийн зэрэг олгох журам”, “Авто зам, замын байгууламжийн ТЭЗҮ, инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах, барих, арчлах, засварлах, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлын тусгай зөвшөөрөл олгох журам”-уудыг боловсруулан батлуулаад байна.

4.2. Автотээврийн талаар:

Монгол, Латвийн автотээврийн төлөөлөгчдийн 2 дахь удаагийн зөвлөлдөх уулзалтыг 2018 оны 06 дугаар сарын 13,14-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулсан. Тус уулзалтаар Монгол, Латвийн хооронд хийгдэж буй тээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлэх, мөн улс хоорондын тээвэрлэлт гүйцэтгэх зөвшөөрлийн бичгийн тоог шинэчлэн тогтоосон.

“Монголын хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбоо” ТББ-тай зам, тээврийн салбарын хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр хамтран ажиллах санамж бичгийг 2018 оны 06 дугаар сарын 21-ний өдөр байгуулав.

Өмнөговь аймгийн Ханбогд сумын Гашуунсухайт боомтод “Авто зогсоолын цогцолбор” барих төсөл хэрэгжүүлэх “Түгээмэлтүмэн хишиг” ХХК-ийн саналыг дэмжиж, шаардлагатай шийдвэрийг гаргуулах хүсэлтийг Өмнөговь аймгийн Засаг дарга, Ханбогд сумын Засаг дарга нарт хүргүүлэв.

Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах, үндэсний үйлдвэрлэлийг дэмжих зорилтын хүрээнд байгаль орчинд ээлтэй “МОН-30” загварын их багтаамжийн цахилгаан автобус 2 ширхгийг нийлүүлэх, туршилт хийх гэрээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.2 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 122 дугаар тогтоолыг үндэслэн “Монгол машин индустриал” ХХК-тай шууд гэрээ байгуулахыг Төрийн нарийн бичгийн даргад зөвшөөрөх тухай Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 133 дугаар тушаалаар батлав.

Уг тушаалыг үндэслэн “Монгол машин индустриал” ХХК-тай цахилгаан автобус нийлүүлэх, турших гэрээг 2018 оны 06 дугаар сарын 20-ны өдөр байгуулав.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл хүссэн “Төгрөг дугаар” ХХК, “Номгон авто” ХХК, “Мега пресс” ХХК, “Ундррам авто” ХХК, “Монголиа леадинг констракшн” ХХК-иудын ирүүлсэн материалуудыг судлан “Тээврийн хэрэгслийн улсын дугаарын тэмдэг үйлдвэрлэх ажил эрхлэх” тусгай зөвшөөрлийг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 144 дүгээр тушаалаар олгов.

4.3.Төмөр замын талаар:

Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объект, үйл ажиллагааны гэрчилгээ шинээр авах болон сунгуулах хүсэлт ирүүлсэн 18 ААН, байгууллагын материалыг хянан шалгаж Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 122 дугаар, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 148 дугаар тушаалаар тус тус шийдвэрлэсэн.

Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объект, үйл ажиллагааны гэрчилгээ шинээр авах болон сунгуулах хүсэлт ирүүлсэн 7 ААН, байгууллагын материалыг хянан шалгаж 2018 оны 06 дугаар сарын 27-ний өдрийн Ажлын хэсгийн хурлаар шийдвэрлэв.

Зам, тээврийн сайдын 2012 оны 120 дугаар тушаалаар батлагдсан Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим, объект үйл ажиллагаанд гэрчилгээ олгох журамд өөрчлөлт оруулахаар холбогдох мэргэжилтнүүдээс санал авч нэгтгэн эцсийн байдлаар 2018 оны 06 дугаар сарын 18-нд хэлэлцүүлэг хийсэн. Журмын төслийг батлуулахаар саналын нэгтгэл, нөлөөллийн шинжилгээг шинэчлэн боловсруулж байна.

“Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх, тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар, олгох” журмыг шинэчлэн боловсруулж Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 119 дүгээр тушаалаар батлуулав.

4.4.Агаарын тээврийн талаар:

Ерөнхий сайдын 2018 оны 105 дугаар захирамжаар шинэчлэн байгуулагдсан ажлын хэсэг нь “Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэхээр санал тавьсан Японы консорциумтай хийж буй концессын гэрээний санхүүгийн загварын талаарх хэлэлцээг 2018 оны 06 дугаар сарын 08, 13-ны өдрүүдэд, Концессын зүйлийн захиргаа удирдлагын нарийвчилсан хуваарилалтын хэлэлцээг 2018 оны 06 дугаар сарын 11, 13-ны өдрүүдэд, мөн Хувьцаа эзэмшигчдийн гэрээний хэлэлцээг 2018 оны 06 дугаар сарын 12, 14-ны өдрүүдэд тус тус хийсэн.

Төслийг хэрэгжүүлэхээр санал тавьсан этгээдийн боловсруулсан гэрээний төсөл нь Ерөнхий сайдын 2018 оны 105 дугаар захирамжаар батлуулсан ажлын хэсгийн хэлэлцээ хийх удирдамжид нийцэхгүй байгаа тул Ажлын хэсгийн 2018 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн хурлаар Монголын талын гэрээний төсөл боловсруулах шийдвэр гаргасан.

Уг шийдвэрийн дагуу Үндэсний хөгжлийн газар, Зам, тээврийн хөгжлийн яам, Иргэний нисэхийн ерөнхий газар болон хууль, санхүүгийн зөвлөх багийн

бүрэлдэхүүнтэйгээр 2018 оны 06 дугаар сарын 18-наас 20-ны өдрүүдэд Монголын талын Концессын гэрээний төслийг боловсруулсан.

Японы талтай 2018 оны 06 дугаар сарын 25-наас 07 дугаар сарын 02-ны өдрүүдэд концессын зүйлийн газрын үйлчилгээний санал, санхүүгийн загварын тооцоолол болон Хувьцаа эзэмшигчдийн гэрээний хэлэлцээг тус тус үргэлжлүүлж байна.

Дэлхийн худалдааны байгууллагын олон талт худалдааны хэлэлцээр болох “Иргэний агаарын хөлгийн худалдааны хэлэлцээр”-т нэгдэх Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийг 2018 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлсэн.

“Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төсөл”-ийн барилгын ажлын нэмэлт гэрээний хүрээнд баригдсан газрын үйлчилгээний барилга, дулаан зогсоолын барилга, харуулын болон шалган нэвтрүүлэх байр, бусад жижиг барилгууд болон тэдгээрт суурилагдсан тоног төхөөрөмжүүд, барилга байгууламжуудын гадна шугам сүлжээний ажлуудад Улсын комисс ажиллуулах тухай хүсэлтийг 2018 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 01/2887 тоот албан бичгээр Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлээд байна.

ТАВ. ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

Монгол Улсын Засгийн газар, БНПолУ, БНЧехУ, ХБНГУ, БНСлоУ, БНУнгар Улсуудтай байгуулах Автотээврийн хэлэлцээрийн төслийг эцэслэн тохиролцов.

ОХУ-ын тээврийн сайд Е.И.Дитрих, Дэд сайд А.В.Лушников нар 2018 оны 06 дугаар сарын 07-09-ний өдрүүдэд Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, дэд сайд Б.Цогтгэрэл болон албаны бусад төлөөлөгчтэй уулзалт хийж Монгол, Оросын зам, тээврийн салбарын хамтын ажиллагааны тухай санал солилцов.

Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ АНУ-ын ЭСЯ-ны Хэргийг түр хамаарагч Мануэл П.Микаллертай уулзалт хийж хоёр орны зам, тээврийн салбарын хамтын ажиллагааны тухай санал солилцов.

Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ Дэлхийн Төв ба Зүүн Хойд Азийн зам, тээврийн асуудал хариуцсан захирал Виням Режа, Монгол дахь суурин төлөөлөгч Жеймс Андерсон нарыг хүлээн авч уулзав.

Зам, тээврийн хөгжлийн сайд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч бөгөөд Буурай, Далайд Гарцгүй Хөгжиж буй Орнууд болон Жижиг Арлын Улсуудын Төлөөлөгч Хатагтай Фекитамоелоа Катоа Утойкамануг 2018 оны 06 дугаар сарын 12-ны өдөр хүлээн авч уулзав.

Зам, тээврийн хөгжлийн яамны ГХАХ-ийн дарга Б.Болор-Эрдэнэ, АТБХЗХ-ийн дарга С.Мөнхнасан нар 2018 оны 06 дугаар сарын 20-ны өдөр Казахстан Улсын агаарын тээврийн СКАТ компанийн төлөөлөгчдийг хүлээн авч хамтын ажиллагааны тухай санал солилцов.

Зам, тээврийн хөгжлийн дэд сайд 2018 оны 06 дугаар сарын 19-ны өдөр Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын төлөөлөгчдийг хүлээн авч Монгол Улсад хэрэгжүүлэх гэж буй “Төв Азид тээврийн холболтыг сайжруулах төсөл”-ийн тухай санал солилцов.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор, ОХУ-ын Аж үйлдвэр, худалдааны яамны дэмжлэгтэйгээр 2018 оны 06 дугаар сарын 07-09-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Монгол-Оросын санаачлага 2018 эдийн засгийн чуулга уулзалтын “Монгол Улсын дэд бүтцийн хөгжил, шинэчлэл, аж үйлдвэр, зам тээвэр, барилгын хамтарсан төслүүдийг хэрэгжүүлэх нь” салбар хуралдаанд Зам, тээврийн хөгжлийн дэд сайд Б.Цогтгэрэл илтгэл тавьж оролцов.

Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ Бүгд Найрамдах Замби Улсын Парламентын гишүүн, Тээвэр харилцаа холбооны сайд Брайн Мушимбаг 2018 оны 06 дугаар сарын 12-ны өдөр хүлээн авч уулзав.

Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ Роснефть компанийн төлөөлөгчдийг хүлээн авч уулзав.

Зам, тээврийн хөгжлийн дэд сайд Б.Цогтгэрэл ИБУИНВУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин Сайд Филип Мапоныг хүлээн авч уулзаж хоёр орны зам, тээврийн салбарын хамтын ажиллагааны тухай санал солилцов.

Монгол, Латвийн Автотээврийн төлөөлөгчдийн хоёр дахь удаагийн зөвлөлдөх уулзалт 2018 оны 06 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд болж, ЗТХЯ-аас АТБХЗГ-ын дарга С.Батболд, ГХАХ-ийн ахлах мэргэжилтэн Б.Нямдаваа нар оролцож уулзалтын дүнгээр Протокол байгуулав.

Гадаад харилцааны яам, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын хамтран зохион байгуулж буй “Төв Азид өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх төсөл”-ийн үр дүнг хэлэлцэж, шинээр хэрэгжүүлэх “Төв Азид тээврийн холболтыг сайжруулах төсөл”-ийн тухай танилцуулга семинарт 2018 оны 06 дугаар сарын 20-ны өдөр Зам, тээврийн хөгжлийн дэд сайд Б.Цогтгэрэл илтгэл тавьж оролцов.

ОХУ-ын Москва хотноо хуралдах Монгол-Оросын хувь нийлүүлсэн “УБТЗ” нийгэмлэгийн Ерөнхий хорооны хуралд 2018 оны 06 дугаар сарын 28-29-ний өдрүүдэд Зам, тээврийн дэд сайд Б.Цогтгэрэл болон тус яамны төлөөллийг оролцуулав.

ЗУРГАА. БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР.

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 146 дугаар тогтоолоор баталсан “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратеги”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хийгдэж байгаа “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах бодлого, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах” Техникийн туслалцаа /ТТ/-ны төслийн /ТА 9137-МОН/ тайлангийн хурлыг 2018 оны 06 дугаар сарын 14-ны өдөр зохион байгуулав. Уг хуралд ХЗДХЯ, НТГ, АТҮТ, ЗТХТ, ЗЦА-ны 80 төлөөлөл хамрагдав.

“Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратеги”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Зам, тээврийн ослын шинжилгээ” онол практикийн хурлыг Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, Замын цагдаагийн газартай хамтран 2018 оны 06 дугаар сарын 21-ны өдөр зохион байгуулж, тус яамнаас илтгэл тавьж оролцов.

“Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг дэмжих жил”-ийн хүрээнд Зам, тээврийн хөгжлийн яам, “Монголын автомашины дистрибьюторуудын ассоциаци” ТББ-тай хамтран “Улаанбаатар Авто Шоу 2018” арга хэмжээг 2018 оны 06 дугаар сарын 08-наас 10-ны өдрүүдэд Мишээл Экспо төвийн үзэсгэлэнгийн танхимд зохион байгуулав.

Монгол улсын Ерөнхий сайдын ивээл дор зохион байгуулсан “Жендэр ба хөгжил” Олон улсын бага хуралд Зам, тээврийн хөгжлийн яамны төлөөллийг оролцуулж, олон улс дахь Жендэрийн эрх зүйн хамгаалалтын талаар мэдээлэл авч ажиллав. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас хэрэгжүүлж буй “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн оролцоог дэмжих төсөл”-ийн 2018 оны эхний хагас жилийн тайланг хэлэлцэх болон 2018 оны сүүлийн хагас жилийн ажлын төлөвлөгөөг хэлэлцэхэд оролцов.

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ